ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Асгат сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2025/045/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улиастай сум<br>2025 он | Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын<br>дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа<br>Утас: 99993365<br>Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Болдбаатар<br>Утас: 99105506<br>Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn<br>Аудитор: О.Алтансувд<br>Утас: 88009224<br>Цахим хаяг: altansuvdo@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт 3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7

3. Санхүүгийн тайлангийн тодруулга....8

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11

4. Аудитын тайлан....13

4.1 Ерөнхий зүйл ....13

4.2 Материаллаг байдал ....14

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт....14

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....14

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....15

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....16

5. Аудитын илрүүлэлт ....16

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

---

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.01 № 014

таны ________ -ны № ________ -т

АСГАТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Д.БАТБИЛЭГ-Д

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Асгат сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Асгат сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Асгат сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 118,747.5 мянган төгрөгийн газар тариалангийн тоног төхөөрөмж, Онцгой байдлын ерөнхий газраас 181,000.00 мянган төгрөгийн "Hilux" автомашин, "Адал" төслөөс 174,506.6 мянган төгрөгийн өвс тэжээлийн агуулах, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас багийн Засаг дарга нарт 5,761.7 мянган төгрөгийн мотоцикл, 3,980.00 мянган төгрөгийн Dell i5 нөүтбүүк, сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 19,950.0 мянган төгрөгийн Аялал жуулчлалын отог, 40,000.0 мянган төгрөгийн нийтийн амралт зугаалгын цэцэрлэгт хүрээлэн, 50,000.0 мянган төгрөгийн нийтийн биеийн тамирын талбай зэрэг хөрөнгө нийлүүлэгдсэнийг данс бүртгэлд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Асгат сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар албан хаагчдад илүү цагийн нэмэгдлийг анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй хавтгайруулж, 6,566,543 төгрөгийг, эрх бүхий албан тушаалтны нэмэгдлийг батлагдсан төсвийн хүрээнд олгоогүй, 40 хувиар 2,493,523 төгрөгийг илүү тооцож олгосон байна.

**Бусад асуудлын хэсэг**

D/disk/Албан бичиг/Дүгнэлт

812502370

Асгат сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг 652,155.3 мянган төгрөгөөр зөрүүтэй хийсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшинийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **21,449,540.00** | **35,049,540.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **21,449,540.00** | **35,049,540.00** |
| **354** | **Хангамжийн материал** | **21,449,540.00** | **35,049,540.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,650,800.00 | 2,250,800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 15,301,740.00 | 15,301,740.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 440,000.00 | 440,000.00 |
| 35460 | Хүнсний материал | | |
| 35470 | Бусад хангамжийн материал | 4,057,000.00 | 17,057,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **691,478,068.47** | **1,240,218,370.08** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **691,478,068.47** | **1,240,218,370.08** |
| **392** | **Биет хөрөнгө** | **662,353,191.27** | **1,211,573,492.88** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 460,839,390.65 | 745,296,000.65 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (120,266,725.18) | (141,839,610.50) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 87,869,800.00 | 275,431,554.60 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (44,304,882.97) | (66,294,882.85) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 356,865,610.40 | 506,173,110.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (112,608,643.87) | (139,245,391.93) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 8,047,716.00 | 13,994,816.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (1,228,153.48) | (3,236,317.00) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 67,089,252.60 | 67,089,252.60 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (41,651,142.88) | (47,496,009.09) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | | |
| 39217 | Ном | 1,700,970.00 | 1,700,970.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **29,124,877.20** | **28,644,877.20** |
| 39301 | Програм хангамж | 3,667,000.00 | 3,667,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,589,500.00) | (3,069,500.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 28,047,377.20 | 28,047,377.20 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **712,927,608.47** | **1,275,267,910.08** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **73,895.67** |

| | | | |
|---|---|---|---|
| **413** | **Өглөг** | **-** | **73,895.67** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 73,895.67 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **398,830,186.13** | **1,275,194,014.41** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **398,830,186.13** | **1,275,194,014.41** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | - | 314,097,422.34 |
| 51101 | Өмч: - төрийн | | 314,097,422.34 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **217,359,696.87** | **779,626,102.81** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 217,359,696.87 | 217,359,696.87 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 562,266,405.94 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 181,470,489.26 | 181,470,489.26 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **398,830,186.13** | **1,275,267,910.08** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **481,144,797.80** | **1,290,225,364.10** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,650,000.00** | **614,106,606.10** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **5,650,000.00** | **599,606,606.10** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **5,650,000.00** | **599,522,964.60** |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 5,650,000.00 | 599,522,964.60 |
| 120009 | Бусад орлого | - | 83,641.50 |
| **122** | **Тусламжийн орлого** | **-** | **14,500,000.00** |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | - | 14,500,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **475,494,797.80** | **676,118,758.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **18,778,397.80** | **43,185,958.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 43,185,958.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 18,778,397.80 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 456,716,400.00 | 632,932,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 456,716,400.00 | 632,932,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **510,159,387.18** | **727,958,958.16** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **510,159,387.18** | **727,958,958.16** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **470,265,988.49** | **659,436,511.28** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **292,933,782.86** | **433,903,354.94** |
| 210101 | Үндсэн цалин | 189,756,761.87 | 265,742,421.36 |
| 210102 | Нэмэгдэл | 83,176,770.99 | 154,733,233.58 |
| 210104 | Урамшуулал | 20,000,250.00 | 13,427,700.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,701,179.14 | 52,669,577.65 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,073,950.84 | 35,948,897.32 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,933,900.00 | 4,374,285.11 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,238,728.30 | 2,420,265.97 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 586,700.00 | 1,983,289.89 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,867,900.00 | 7,942,839.36 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,733,848.45 | 30,782,549.70 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,204,776.45 | 3,719,413.70 |
| 210302 | Түлш, халаалт | 22,529,072.00 | 27,063,136.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 38,200,434.00 | 37,669,378.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,472,200.00 | 3,909,550.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 30,451,234.00 | 25,961,928.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,277,000.00 | 1,212,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 4,102,400.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 2,483,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,794,750.00 | 10,800,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,794,750.00 | 10,800,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 8,510,500.00 | 9,684,935.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,510,500.00 | 9,684,935.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,903,525.00 | 2,276,553.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,822,000.00 | 1,705,730.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 353,000.00 | 193,960.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 203,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 310,000.00 | 173,463.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **54,487,969.04** | **81,650,162.99** |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,514,516.00 | 3,117,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 533,000.00 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 37,440,453.04 | 78,532,662.99 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **39,893,398.69** | **68,522,446.88** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **23,682,800.00** | **62,937,026.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 23,682,800.00 | 33,393,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 29,543,126.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **16,210,598.69** | **5,585,420.88** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,210,598.69 | 5,585,420.88 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(29,014,589.38)** | **562,266,405.94** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(29,014,589.38)** | **562,266,405.94** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **475,494,797.80** | **676,202,399.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | - | **83,641.50** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 83,641.50 |
| 120009 | Бусад орлого | - | 83,641.50 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **475,494,797.80** | **676,118,758.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 18,778,397.80 | 43,185,958.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 43,185,958.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 18,778,397.80 | - |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 456,716,400.00 | 632,932,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 456,716,400.00 | 632,932,800.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **475,183,755.00** | **662,952,399.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **475,183,755.00** | **662,952,399.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **435,290,356.31** | **594,429,952.62** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 292,933,782.86 | 432,801,576.98 |
| 210101 | Үндсэн цалин | 189,756,761.87 | 257,189,617.34 |

| | | | |
|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 83,176,770.99 | 162,282,259.64 |
| 210104 | Урамшуулал | 20,000,250.00 | 13,329,700.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **36,674,000.00** | **53,943,244.94** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,046,771.70 | 37,222,563.61 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,933,900.00 | 4,374,285.11 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,238,728.30 | 2,420,266.97 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 586,700.00 | 1,983,289.89 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,867,900.00 | 7,942,839.36 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **26,733,848.45** | **30,782,549.70** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,204,776.45 | 3,719,413.70 |
| 210302 | Түлш, халаалт | 22,529,072.00 | 27,063,136.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **31,767,152.00** | **26,278,078.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 6,997,200.00 | 3,214,050.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,492,952.00 | 21,851,928.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,277,000.00 | 1,212,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **9,851,750.00** | **12,255,400.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,851,750.00 | 11,655,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **8,510,500.00** | **9,410,800.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,510,500.00 | 9,410,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **6,903,525.00** | **2,304,903.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,822,000.00 | 1,734,080.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 396,525.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 353,000.00 | 193,960.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 203,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 310,000.00 | 173,463.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **21,915,798.00** | **26,653,400.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,382,798.00 | 26,350,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 533,000.00 | 303,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **39,893,398.69** | **68,522,446.88** |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **23,682,800.00** | **62,937,026.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 23,682,800.00 | 33,393,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 29,543,126.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **16,210,598.69** | **5,585,420.88** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,210,598.69 | 5,585,420.88 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **311,042.80** | **13,250,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **13,250,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 13,250,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(13,250,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 311,042.80 | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооний нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 314,097,422.34 | 181,470,489.26 | 240,113,329.05 | 735,681,240.65 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **C03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **314,097,422.34** | **181,470,489.26** | **240,113,329.05** | **735,681,240.65** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (22,753,632.18) | (22,753,632.18) |
| **C08** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **314,097,422.34** | **181,470,489.26** | **217,359,696.87** | **712,927,608.47** |
| **D01** | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **314,097,422.34** | **181,470,489.26** | **217,359,696.87** | **712,927,608.47** |
| **D03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **314,097,422.34** | **181,470,489.26** | **217,359,696.87** | **712,927,608.47** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 562,266,405.94 | 562,266,405.94 |
| **D09** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **314,097,422.34** | **181,470,489.26** | **779,626,102.81** | **1,275,194,014.41** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| **Код** | **Үзүүлэлт** | **Төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **Зөрүү дүн** | **Харьц уулалт** |
|---|---|---|---|---|---|
| **80101 - ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** | | | | | |
| **1220** | **Тусламжийн орлого** | **461,823,900.00** | **448,748,641.50** | **13,075,258.50** | **97.17** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 122005 | Төсвөөс санхүүжих | 461,823,900.00 | 448,748,641.50 | 13,075,258.50 | 97.17 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **362,259,700.00** | **349,598,428.18** | **12,661,271.82** | **96.5** |
| 210101 | Үндсэн цалин | 212,487,600.00 | 202,778,183.00 | 9,709,417.00 | 95.43 |
| 210102 | Нэмэгдэл | 149,772,100.00 | 135,754,795.18 | 14,017,304.82 | 90.64 |
| 210104 | Урамшуулал | | 11,065,450.00 | - 11,065,450.00 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **45,282,500.00** | **45,059,799.25** | **222,700.75** | **99.51** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,792,100.00 | 31,181,820.54 | -389,720.54 | 101.27 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,622,600.00 | 3,663,609.47 | -41,009.47 | 101.13 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,898,100.00 | 2,064,929.14 | 833,170.86 | 71.25 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 724,500.00 | 1,627,952.06 | -903,452.06 | 224.7 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,245,200.00 | 6,521,488.04 | 723,711.96 | 90.01 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **30,605,000.00** | **30,582,549.70** | **22,450.30** | **99.93** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,831,600.00 | 3,719,413.70 | -887,813.70 | 131.35 |
| 210302 | Түлш, халаалт | 27,773,400.00 | 26,863,136.00 | 910,264.00 | 96.72 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **12,000,000.00** | **12,000,000.00** | | **100** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,199,200.00 | 2,602,450.00 | -403,250.00 | 118.34 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,708,200.00 | 8,185,450.00 | -477,250.00 | 106.19 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,092,600.00 | 1,212,100.00 | 880,500.00 | 57.92 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **834,500.00** | **834,500.00** | | **100** |
| 210604 | Урсгал засвар | 834,500.00 | 834,500.00 | | 100 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **9,410,800.00** | **9,410,800.00** | | **100** |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,410,800.00 | 9,410,800.00 | | 100 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,128,000.00** | **570,823.00** | **557,177.00** | **50.6** |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 409,000.00 | | 409,000.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 227,700.00 | 193,960.00 | 33,740.00 | 85.18 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 28,600.00 | | 28,600.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 203,400.00 | 203,400.00 | | 100 |
| 210807 | Газрын төлбөр | 259,300.00 | 173,463.00 | 85,837.00 | 66.9 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **303,400.00** | **303,400.00** | | **100** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 303,400.00 | 303,400.00 | | 100 |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 388,341.37 | -388,341.37 | |
| **80106 - БАГ, ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** | | | | | |
| **1220** | **Тусламжийн орлого** | **95,851,900.00** | **95,851,900.00** | | **100** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 95,851,900.00 | 95,851,900.00 | | 100 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **83,737,500.00** | **83,203,148.80** | **534,351.20** | **99.36** |
| 210101 | Үндсэн цалин | 83,737,500.00 | 54,411,434.34 | 29,326,065.66 | 64.98 |
| 210102 | Нэмэгдэл | | 26,527,464.46 | - 26,527,464.46 | |
| 210104 | Урамшуулал | | 2,264,250.00 | -2,264,250.00 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **10,467,300.00** | **8,883,445.69** | **1,583,854.31** | **84.87** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,117,700.00 | 6,040,743.07 | 1,076,956.93 | 84.87 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 837,400.00 | 710,675.64 | 126,724.36 | 84.87 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 669,900.00 | 355,337.83 | 314,562.17 | 53.04 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 167,500.00 | 355,337.83 | -187,837.83 | 212.14 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,674,800.00 | 1,421,351.32 | 253,448.68 | 84.87 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 200,000.00 | 200,000.00 | | 100 |
| 210302 | Түлш, халаалт | 200,000.00 | 200,000.00 | | 100 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,426,200.00** | **1,426,200.00** | | **100** |
| 210401 | Бичиг хэрэг | 234,000.00 | 311,600.00 | -77,600.00 | 133.16 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,068,000.00 | 1,114,600.00 | -46,600.00 | 104.36 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 124,200.00 | | 124,200.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **20,900.00** | **20,900.00** | | **100** |
| 210604 | Урсгал засвар | 20,900.00 | 20,900.00 | | 100 |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 2,118,205.51 | -2,118,205.51 | |
| **80205 - МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААНЫ ЗАРДАЛ** | | | | | |
| **1220** | **Тусламжийн орлого** | **1,200,000.00** | **1,200,000.00** | | **100** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 1,200,000.00 | 1,200,000.00 | | 100 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,200,000.00** | **1,200,000.00** | | **100** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,200,000.00 | 1,200,000.00 | | 100 |
| **80802 - АЖИЛ ОЛГОГЧООС ОЛГОХ ТЭТГЭМЖ УРАМШУУЛАЛ, ДЭМЖЛЭГ** | | | | | |
| **1220** | **Тусламжийн орлого** | **66,015,900.00** | **66,015,900.00** | | **100** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 66,015,900.00 | 66,015,900.00 | | 100 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **66,015,900.00** | **62,937,026.00** | **3,078,874.00** | **95.34** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 33,393,900.00 | 33,393,900.00 | | 100 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 32,622,000.00 | 29,543,126.00 | 3,078,874.00 | 90.56 |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 3,078,874.00 | -3,078,874.00 | |
| **81102 - ОРОН НУТГИЙН НӨӨЦ ХӨРӨНГӨ** | | | | | |
| **1220** | **Тусламжийн орлого** | **20,000,000.00** | **20,000,000.00** | | **100** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 20,000,000.00 | 20,000,000.00 | | 100 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **20,000,000.00** | **20,000,000.00** | | **100** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,000,000.00 | 20,000,000.00 | | 100 |
| **1220** | **Тусламжийн орлого** | **1,677,500.00** | **1,200,000.00** | **477,500.00** | **71.54** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 1,677,500.00 | 1,200,000.00 | 477,500.00 | 71.54 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,677,500.00** | **1,200,000.00** | **477,500.00** | **71.54** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,677,500.00 | 1,200,000.00 | 477,500.00 | 71.54 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | | | | |

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл | |
|---|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | - | **43,185,958.00** | |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | - | **29,935,958.00** | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 12,851,878.00 | |
| 210401 | Бичиг хэрэг | - | 300,000.00 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 12,551,878.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 11,400,000.00 | |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 600,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | - | 10,800,000.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 534,080.00 | |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 534,080.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 5,150,000.00 | |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 5,150,000.00 | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | | |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | **13,250,000.00** | |
| 225001 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 13,250,000.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | **43,185,958.00** | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | **43,185,958.00** | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 43,185,958.00 | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

**3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

***<u>Асгат сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэл:</u>***

- *<u>Иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэх</u>*

***<u>Асгат сумын Засаг даргын Тамгын газрын зорилго</u>:*** Иргэд олон нийтийн санал санаачлагад тулгуурлан төрийн үйлчилгээг иргэн бүрт шуурхай, жигд, хүртээмжтэй, үнэнч шударгаар хүргэж оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлэх чадварлаг, үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх, сум орон нутгаа хөгжүүлэх гэсэн зорилго зорилт чиг үүргийн хүрээнд ажилладаг байна.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 101 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс ... хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

*Асгат сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд мөрддөг хууль:*

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд Тамгын газрын дарга, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Асгат сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Асгат сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 562,340.3 мянган төгрөгөөр буюу 44.1 хувиар өссөн байна.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 0.00 | 0.00 | |
| Бараа материал | 21,449.5 | 35,049.5 | 13,600.0 |
| Үндсэн хөрөнгө | 1,014,127.1 | 1,240,218.3 | 226,091.2 |
| **Нийт хөрөнгө** | **712,927.6** | **1,275,267.9** | **562,340.3** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 712,927.6 | 1,275,194.0 | 562,266.4 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **712,927.6** | **1,275,267.9** | **562,340.3** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Бараа материалын эхний үлдэгдэл 21,449.5 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 53,257.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 39,657.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 35,049.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 13,600.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 13,250.0мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандиваар 14,500.0 мянган төгрөг, хөрөнгө оруулалтаар 599,522.9 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, жилийн эцэст 1,641,400.0 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 78,532.6 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 562,340.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 646,569.2 мянган төгрөг, нийт зарлагыг 633,016.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, Засаг даргын нөөц хөрөнгийг тодотголоор нэмж баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 646,569.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 633,016.4 мянган төгрөг буюу 97.1 хувьтай байна. Энэ нь гэрэл цахилгаан, шуудан холбоо, хичээл үйлдвэрлэлийн дадлага, мэдээлэл сурталчилгаа

зэрэг зардлыг 13,075.2 мянган төгрөгөөр, байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас 477,5 мянган төгрөгийг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | | | | |
| **70106** | **Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага** | | | | |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 461,823.9 | 448,748.6 | 13,075.2 | 97.17% |
| 80106 | Баг, хорооны үйл ажиллагааны зарлал | 95,851.9 | 95,851.9 | | 84.87% |
| 80205 | Мэдээлэл, сурталчилгааны зардал | 1,200.0 | 1,200.0 | | 100% |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 66,015.9 | 66,015.9 | | 95.3% |
| 81102 | Орон нутгийн нөөц хөрөнгө | 20,000.0 | 20,000.0 | | 100% |
| 81701 | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 1,677.5 | 1,200.0 | 477.5 | 71.5% |
| **НИЙТ** | | **646,569.2** | **633,016.4** | **13,552.7** | **94.7%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 43,185.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлснээс, Гүйцэтгэлээр 43,185.9 мянган төгрөгийг бичиг хэрэг, тээвэр шатахуун, багаж, техник хэрэгсэл, тавилга, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/мянган төгрөг/*

| № | Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| 1 | Шууд гэрээ байгуулах | Тавилга , эд хогшил | 5,000.0 | 4,850.0 |
| 2 | Шууд гэрээ байгуулах | Зөөврийн компьютер, өнгөт принтер | 8,500.0 | 8,400.0 |
| **ДҮН** | | | **13,250.0** | **13,250.0** |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн

газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Асгат сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Алтансувд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Асгат сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 03/34 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 348,669.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 6,973.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,230.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, санхүүгийн үр дүнгийн тайлан өөрчлөгдсөн тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн, үр дүнгийн тайлангийн 1,131,018.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 22,620.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 16,965.2 мянган төгрөгөөр тогтоосон.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 59 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Асгат сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдэж, алдаа зөрчил илрээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 449,682.0 мянган төгрөгийн зөрчилд 5 заалт зөвлөмж, 15,852.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 282.0 | 1 | 282.0 | 100% |
| Албан шаардлага | 2 | 26,031.6 | 2 | 26,031.6 | 100% |
| Зөвлөмж | 2 | 7,600.0 | 2 | 7,600.00 | 100% |
| **Нийт дүн** | **5** | **33,913.6** | **5** | **33,913.6** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 26,738.6 мянган төгрөгийн алдаа илэрч, аудитын явцад залрууллаа.

***Залруулсан алдаа:***

Тайлант онд Мөнгөн гүйлгээний тайланд зардлын эдийн засгийн ангилал 13,738.1 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зорилгоор нэг бүрийн үнэ 20.0 мянган төгрөгөөр 650 шуудай хивэг 13,000.0 мянган төгрөгөөр худалдан авч, анхан шатны баримтгүй зардалд тусгасан алдааг залруулсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасан, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-тай нийцэхгүй, толилуулга, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 678,893.5 мянган төгрөгийн зөрчил илэрч, илүү цагийн нэмэгдлийг анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй хавтгайруулж, эрх бүхий албан тушаалтны нэмэгдлийг батлагдсан төсвийн хүрээнд олгоогүй, 40 хувиар илүү тооцож олгосон, жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг зөрүүтэй хийсэн зөрчилд 3 заалт зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн 687,953.5 мянган төгрөгийн зөрчлөөс 652,155.3 мянган төгрөгийн зөрчлийг нь шинж чанарын хувьд материаллаг гэж үзэж, 9,060.0 мянган төгрөгийн нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 13,560.3 мянган төгрөгөөр бага, "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

**5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй**

**5.2 Албан шаардлага өгөгдөөгүй**

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

***Илрүүлэлт***: Эрх бүхий албан тушаалтны нэмэгдлийг батлагдсан төсвийн хүрээнд олгоогүй, 40 хувиар тооцож, 2,493.5 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2-т "бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж***: Эрх бүхий албан тушаалтны нэмэгдлийг батлагдсан төсвийн хүрээнд 20 хувиар тооцож олгох;

***2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

***Илрүүлэлт***: Албан хаагчид илүү цагийн нэмэгдлийг анхан шатны баримтын бүрдэл хангалтгүйгээр хавтгайруулж, 6,566.5 мянган төгрөгийг тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 4-д "Төрийн албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын хавсралт хүснэгтийн үндэслэл хэсэгт 1.4.1-1.4.4, 1.5.1-1.5.2-т зааснаас тохирохыг сонгож бөглөнө. Ажлын товч агуулга гэсэн хэсэгт нэмэгдэл хөлс тооцох цагт гүйцэтгэсэн ажлын товч агуулгыг үндэслэл тус бүрээр бичнэ" гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж***: Албан хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлсийг чиг үүрэгт хамаарахгүй ажилд хавтгүйрүүлж олгохгүй байх, илүү цагийн нэмэгдэл олгосон тохиолдолд анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж ажиллах;

***3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

***Илрүүлэлт***: Байгууллагын 2024 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг 652,155.3 мянган төгрөгөөр зөрүүтэй хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-д "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 12 дугаар зүйлийн 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 12.2.2-д "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", 12.2.3-д "эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан

авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэгтэй" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***<u>Өгсөн зөвлөмж</u>***: Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд үнэн зөв хийж, үр дүнг тооцож, үлдэгдлийг баталгаажуулан, баримтжуулж байх;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнэлэс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Мөнгөн гүйлгээний тайланд зардал буруу бүртгэсэн. | 1 | 13,738.2 | | | 1 | 13,738.2 | 1 | 13,738.2 | | | | |
| Нэг бүрийн үнэ 20.0 төгрөгөөр 650 шуудай хэвэг худалдан авалт хийж худалдан авч | 1 | 13,000.0 | | | 1 | 13,000.0 | 1 | 13,000.0 | | | | |
| **Дүн** | **2** | **26,738.2** | | | **2** | **26,738.2** | | **26,738.2** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнэлэс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг зөрүүтэй хийсэн | 1 | 652,155.3 | | | | | 1 | 652,155.3 | | | | |
| ЭБАТ-ын нэмэгдлийг батлагдсан төсвийн хүрээнд олгоогүй, 40 хувиар илүү тооцож олгосон байна. | | 2,493.5 | | | | | 1 | 2,493.5 | | | | |
| Илүү цагийн нэмэгдлийг албан хаагчид хавтгайруулж , анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй тооцож олгосон. | 1 | 6,566.5 | | | | | 1 | 6,566.5 | | | | |
| **Дүн** | **3** | **661,215.3** | | | | | **3** | **661,215.3** | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Д.БАТ-ҮНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР: Ж.БОЛДБААТАР

Огноо: 2025-02-20

**БОЛОВСРУУЛСАН:**

АУДИТОР О.АЛТАНСУВД

Огноо: 2025-02-20